



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Соёл мэдээллийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/77/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn
Аудитор: Б.Азжаргал
Утас: 70350757 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа	14
4.4 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.23 № 10
танай _____-ны № _____-т

ЖАРГАЛАНТ СУМЫН СОЁЛ
МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ
Б.ОЮУНГЭРЭЛ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын Соёл мэдээллийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын Соёл мэдээллийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл аудитлагдаагүй	Эхний үлдэгдэл аудитлагдсан
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>12,284,774.35</u>	<u>12,284,774.35</u>
33	АВЛАГА	1,757,726.45	1,757,726.45
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	91,118.00	91,118.00
3351	Байгууллагаас авах авлага	54,430.45	54,430.45
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,612,178.00	1,612,178.00
35	БАРАА МАТЕРИАЛ	10,527,047.90	10,527,047.90
351	Түүхий эд материал	9,264,177.90	9,264,177.90
35110	Тусгай зориулалттай материал	9,264,177.90	9,264,177.90
354	Хангамжийн материал	1,262,870.00	1,262,870.00
35420	Аж ахуйн материал	1,262,870.00	1,262,870.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>547,288,110.18</u>	<u>547,288,110.18</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	547,288,110.18	547,288,110.18
392	Биет хөрөнгө	544,755,665.74	544,755,665.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	545,960,464.24	545,960,464.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	(26,614,852.40)	(26,614,852.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	42,354,400.00	42,354,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(35,578,536.10)	(35,578,536.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,853,320.00	21,853,320.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,624,308.74)	(13,624,308.74)
39209	Зам, гүүрийн байгууламж	4,625,470.03	4,625,470.03
39210	Хуримтлагдсан элэгдэл	(772,740.29)	(772,740.29)
39217	Ном	6,552,449.00	6,552,449.00
393	Биет бус хөрөнгө	2,532,444.44	2,532,444.44
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(435,555.56)	(435,555.56)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,518,000.00	2,518,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>559,572,884.53</u>	<u>559,572,884.53</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>216,956.09</u>	<u>216,956.09</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	216,956.09	216,956.09
413	Өглөг	216,956.09	216,956.09
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	214,856.09	214,856.09
4136	Бусад өглөг	2,100.00	2,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	559,355,928.44	559,355,928.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	114,709,415.80	114,709,415.80
	Дахин үнэлгээний нөөц	518,818,169.85	518,818,169.85
512	Хуримтлагдсан үр дүн	(74,171,657.21)	(74,171,657.21)
51210	Өмнөх үеийн үр дүн	(74,171,657.21)	(74,171,657.21)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>559,572,884.53</u>	<u>559,572,884.53</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Аудитлагдаагүй	Аудитлагдсан
		Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	146,685,900.00	146,685,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,835,500.00	38,835,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	38,835,500.00	38,835,500.00
1330	Төсвийн захирагчдаас	107,850,400.00	107,850,400.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	107,850,400.00	107,850,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	132,949,074.25	132,949,074.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	132,949,074.25	132,949,074.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	53,507,644.22	53,507,644.22
210101	Үндсэн цалин	45,497,958.34	45,497,958.34
210102	Нэмэгдэл	6,682,285.88	6,682,285.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,327,400.00	1,327,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,845,269.91	5,845,269.91
210201	Тэтгэврийн даатгал	3,996,337.75	3,996,337.75
210202	Тэтгэмжийн даатгал	462,433.04	462,433.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	369,706.40	369,706.40
210204	Ажилгүйдлийн даатгал	92,326.64	92,326.64
210205	Эрүүл мэндийн даатгал	924,466.08	924,466.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,779,226.44	29,779,226.44
210301	Гэрэл, цахилгаан	837,251.87	837,251.87
210302	Түлш, халаалт	28,512,000.00	28,512,000.00
210303	Цэвэр, бохир ус	429,974.57	429,974.57
2104	Хангамж, бараа материалын зардал	2,828,000.00	2,828,000.00
210401	Бичиг хэрэг	1,289,200.00	1,289,200.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	472,800.00	472,800.00
210404	Ном, хэвлэл	66,000.00	66,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	300,000.00
2105	Нормативт зардал	77,400.00	77,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	77,400.00	77,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,003,000.00	2,003,000.00
210604	Урсгал засвар	2,003,000.00	2,003,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,180.00	50,180.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,000.00	25,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	13,736,825.75	13,736,825.75

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

АУДИТЛАГДААГҮЙ						
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	114,709,415.80	518,818,169.85	(74,171,657.21)		559,355,928.44
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	114,709,415.80	518,818,169.85	(74,171,657.21)	-	559,355,928.44
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	114,709,415.80	518,818,169.85	(74,171,657.21)	-	559,355,928.44
D08	Тайлант үеийн үр дүн			13,736,825.75		13,736,825.75
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	114,709,415.80	518,818,169.85	(60,434,831.46)	-	573,092,754.19

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Аудитлагдаагүй	Аудитлагдсан
		Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>107,850,400.00</u>	<u>107,850,400.00</u>
1330	Төсвийн захирагчдаас	107,850,400.00	107,850,400.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	107,850,400.00	107,850,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	107,850,400.00	107,850,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	107,850,400.00	107,850,400.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	53,507,644.22	53,507,644.22
210101	Үндсэн цалин	45,497,958.34	45,497,958.34
210102	Нэмэгдэл	6,682,285.88	6,682,285.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,327,400.00	1,327,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,060,126.00	6,060,126.00
210201	Тэтгэврийн даатгал	4,211,193.84	4,211,193.84
210202	Тэтгэмжийн даатгал	462,433.04	462,433.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	369,706.40	369,706.40
210204	Ажилгүйдлийн даатгал	92,326.64	92,326.64
210205	Эрүүл мэндийн даатгал	924,466.08	924,466.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,779,226.44	29,779,226.44
210301	Гэрэл, цахилгаан	837,251.87	837,251.87

Жаргалант сумын Соёл мэдээллийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	28,512,000.00	28,512,000.00
210303	Цэвэр, бохир ус	429,974.57	429,974.57
2104	Хангамж, бараа материалын зардал	2,828,000.00	2,828,000.00
210401	Бичиг хэрэг	1,289,200.00	1,289,200.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	472,800.00	472,800.00
210404	Ном, хэвлэл	66,000.00	66,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	300,000.00
2105	Нормативт зардал	77,400.00	77,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	77,400.00	77,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,005,100.00	2,005,100.00
210604	Урсгал засвар	2,005,100.00	2,005,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	200,180.00	200,180.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	175,000.00	175,000.00
210807	Газрын төлбөр	25,180.00	25,180.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	550,000.00	550,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	550,000.00	550,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,842,723.34	12,842,723.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,842,723.34	12,842,723.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	95,692,400.00	103,895,075.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	95,692,400.00	103,895,075.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95,142,400.00	103,695,075.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	60,204,200.00	60,204,200.00
210101	Үндсэн цалин	50,108,300.00	50,108,300.00
210102	Нэмэгдэл	7,675,900.00	7,675,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,420,000.00	2,420,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,127,500.00	8,127,500.00
210201	Тэтгэврийн даатгал	5,719,400.00	5,719,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	602,000.00	602,000.00

Жаргалант сумын Соёл мэдээллийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	481,600.00	481,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	120,400.00	120,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,204,100.00	1,204,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,699,900.00	28,640,895.17
210301	Гэрэл, цахилгаан	2,361,900.00	1,380,369.29
210302	Түлш, халаалт	16,038,000.00	26,730,000.10
210303	Цэвэр, бохир ус	1,300,000.00	530,525.78
2104	Хангамж, бараа материалын зардал	2,885,900.00	2,841,200.00
210401	Бичиг хэрэг	1,292,000.00	1,291,300.00
210402	Тээвэр, шатахуун	544,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	472,800.00	472,800.00
210404	Ном, хэвлэл	77,100.00	77,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	300,000.00
2105	Нормативт зардал	77,400.00	77,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	77,400.00	77,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	955,100.00	955,100.00
210604	Урсгал засвар	955,100.00	955,100.00
2107	Томилолт, зочны зардал	622,000.00	304,000.00
210702	Дотоод албан томилолт	622,000.00	304,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,570,400.00	2,545,180.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,800,000.00	1,800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210807	Газрын төлбөр	50,400.00	25,180.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	550,000.00	200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	550,000.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	550,000.00	200,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	107,977,400.00	107,995,900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	107,705,400.00	107,850,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	107,705,400.00	107,850,400.00

Жаргалант сумын Соёл мэдээллийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	272,000.00	145,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	272,000.00	145,500.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын Соёл мэдээллийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Азжаргал гүйцэтгэж хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын Соёл мэдээллийн төв 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төрөөс баримтлах соёлын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, иргэдийн соёлын боловсролыг нэмэгдүүлж тэдний авьяас чадварыг нээн хөгжүүлэх, соёлын биет болон биет бус өв, түүхийн дурсгалт газруудыг хамгаалах, олон нийтэд сурталчлах, соёл, урлагийн олон талт үйл ажиллагааг чанартай, үр дүнтэй зохион байгуулах, улсын тэргүүлэх туршлага арга зүйг үйл ажиллагаандаа нэвтрүүлж хүний нөөцөө чадвахжуулах зорилго бүхий байгууллага бөгөөд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ. Үүнд:

1. Төрөөс баримтлах соёлын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, иргэдийн соёлын боловсролыг нэмэгдүүлж тэдний авьяас чадварыг нээн хөгжүүлэх
2. Соёлын биет болон биет бус өв, түүхийн дурсгалт газруудыг хамгаалах, олон нийтэд сурталчлах түгээн дэлгэрүүлэх
3. Соёл, урлагийн олон талт үйл ажиллагааг чанартай, үр дүнтэй зохион байгуулах
4. Улсын тэргүүлэх туршлага арга зүйг үйл ажиллагаандаа нэвтрүүлж хэвшүүлэх
5. Хүний нөөцөө тогтмол чадвахжуулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын Соёл мэдээллийн төв 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв болох 107,851.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,078.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 754.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад өөрчлөөгүй болно.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Жаргалант сумын Соёл мэдээллийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,519.8 мянган төгрөгөөр буюу 2.42 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Бараа материал	10,527.0	10,677.0	150.0
Үндсэн хөрөнгө	542,288.1	560,658.0	18,369.9
Нийт хөрөнгө	559,572.9	573,092.7	13,519.8
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	559,572.9	573,092.7	13,519.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	559,572.9	573,092.7	13,519.8

Бараа материалын данс 10,677.0 мянган төгрөг болж 150.0 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал худалдан авсанаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 560,658.0 мянган төгрөг болж 18,369.9 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн өмчийн газраас шилжүүлсэн хөрөнгө байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 573,092.7 мянган төгрөг болж 13,519.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Жаргалант сумын Соёл мэдээллийн төв 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 117,850.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 117,850.4 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 107,851.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Соёл урлагийн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр 78,071.2 мянган төгрөгийг улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр орон нутгийн төсвөөс 29,779.2 мянган төгрөгийн нийт 107,850.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 95,007.7 мянган төгрөгийг зарцуулж, 12,842.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 95,007.7 мянган төгрөг буюу 88.8 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 6,697.5 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,067.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,194.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2,370.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Жаргалант сумын Соёл мэдээллийн төв нь нэмэлт төсвийн дансгүй

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Жаргалант сумын Соёл мэдээллийн төв нь 2021 онд нийт 78,072.4 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 20 мэдээллийг хугацаа хоцроон мэдээллэсэн бөгөөд 131 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин зарлагын гүйлгээ хийхдээ цахим төлбөрийн е-баримтгүй зөвхөн нэхэмжлэхтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 78,710.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж хэрэгжилт хангагдаагүй байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Зөвлөмж	1	78,710.0			1	78,710.0	
Нийт дүн	1	78,710.0			1	78,710.0	

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 80,565.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 222.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 78,585.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж, 1,757.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Зардлын зүйл ангийг буруу сонгосоноор санхүүгийн үр дүнгийн тайланд 222.5 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэнийг залруулав.

4.2 Төлбөрийн акт Байхгүй

4.3 Албан шаардлага

4.3.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн аудитаар 1,757.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Зарлагын гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй дутуу баримтаар гүйлгээ хийсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн зарцуулалтад үр дүнтэй хяналт хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, журмын хэрэгжилтийг хангуулах. Бараа материалын бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх.

1.3. Илрүүлэлт:

151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 20 мэдээллийн 78,072.4 мянган төгрөгийн мэдээг хугацаа хоцроож мэдээллэсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд", 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ," 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.4. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд хугацаа хоцролгүй мэдээлж байх

Жаргалант сумын Соёл мэдээллийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сумын Соёл мэдээллийн төв	4	80,565.7	1	222.5			1	1,757.4	2	78,585.8